



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 4 сарын 11 өдөр

Дугаар 1/02

Мандалговь

Г

Г

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутгийн ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдад мэргэжлээ зөв сонгоход нь туслах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг "Их дээд сургуулиудын өдөрлөг 2017" арга хэмжээг 2017 оны 04 сарын 28-ний өдөр аймгийн төвд зохион байгуулсугай.


Хоёр. Арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- | | |
|-----------------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч: | Ц.Бумангэрэл -Боловсрол, соёл, урлагийн газрын дарга |
| Нарийн бичгийн дарга: | Г.Хишигдаваа -Хөдөлмөр, халамжийн, үйлчилгээний газрын дарга |
| Гишүүд: | Ш.Оюун -Аймгийн Иргэдийн Тэргүүлэгчдийн Хурлын мэргэжилтэн |
| | Б.Хандмаа -Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн |
| | Д.Доржсүрэн -Төв халхын дуулалт жүжгийн театрын дарга |
| | М.Энхбаяр - "Мандал" сургуулийн захирал |
| | А.Ууганбаяр -"Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театрын захирал |
| | Ю.Цолмон -Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал |
| | Г.Цэрэнчимэд -Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн |

Гурав. "Их дээд сургуулиудын өдөрлөг 2017" арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Бумангэрэл/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ



020000274